



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2016 оны 04 сарын 19 өдөр

Дугаар 1129

Улаанбаатар хот

Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчигээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.3 дах хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Дархлаажуулалтын сангийн хөрөнгөөр 2016 онд худалдан авах вакцин, биобэлдмэл, зүү тариур худалдан авах ЭМСЯ-В/2016/01 тендерийн Багц-2 буюу Хачигт энцефалитын эсрэг вакцин, багц 6 буюу Сальмонеллэзын нян залгиур, Багц 7 буюу Балнадын нян залгиур, багц 13 буюу Цусан суулгын олон цэнт нян залгиур, багц 15 буюу Боомын эсрэг иммуноглобулин, багц 16 буюу Стафилококкын анатоксин худалдан авах 141,823,000 /Нэг зуун дөчин нэгэн сая найман зуун хорин гурван мянга/ төгрөгийн төсвийн зарцуулах эрх /гэрээ байгуулах, сунгах, цуцлах, хяналт тавих/-ийг Халдварт өвчин судлалын үндэсний төв /Д.Нямхүү/-д шилжүүлсүгэй.

2. Худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулж ажиллахыг Халдварт өвчин судлалын үндэсний төв /Д.Нямхүү/-д даалгасугай.

3. Эрх шилжүүлсэнтэй холбогдуулан ажлын гүйцэтгэл, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Стратегийн бодлого төлөвлөлтийн газрын Санхүү, эдийн заагийн холтоо /Г.Баярсайхан/-т даалгасугай.

САЙДЫН ҮҮРЭГ  
ГҮЙЦЭТГЭГЧ



Ц.ОЮУНБААТАР

080453